

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### САЙНШАНД СУМ ЗАЛУУЧУУД-1 ГУДАМЖНЫ 103, 105-Р БАЙР, ЗАЛУУЧУУД-3 ГУДАМЖНЫ 36-Р БАЙРНЫ ГАДНА АВТО ЗОГСООЛ БАЙГУУЛАХ АЖИЛ

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **7 200 000 / Долоон сая хоёр зуун мянга /** төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "Ү" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТХС-ын 2022.08.22-ны өдрийн А/233 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТХС-ын 2017 оны 212 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

3. Газар шорооны ажлын хийж гүйцэтгэхийн өмнө геодези хэмжилтийн эрхтэй байгууллагаар шугам трассын дагуу улаан шугам тавиулж илд далд ажлын актыг баталгаажуулсаны дараа ажлын эхлүүлэх шаардлагатай. Улаан шугам тавиулах үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байцуулна.

#### 1. 103, 105-р байрны гадна бетон зогсоолын ажил

Газар шороо болон суурийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 50-02-17г, Авто зогсоолын ажлын хийж гүйцэтгэхдээ БНБД 21-05-10г мөрдлөг болгон ажиллана. Ажил гүйцэтгэх хугацаанд Барилга хот байгуулалтын сайдын 2017.11.30-ны 195 дугаар "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам"-ын мөрдлөг болгон ажиллана. Авто зогсоолд дүрэм журмын дагуу тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэнэ.

#### 2. 103, 105-р байрны явган замын ажил

Явган хүний замын хашлага тавьж, хучилтыг өнгөт хавтангаар хийж гүйцэтгэнэ. Явган хүний замын ажлыг гүйцэтгэхдээ MNS 6808:2019 стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

#### 3. 36-р байрны гадна бетон зогсоолын ажил

Газар шороо болон суурийн ажлыг хийж гүйцэтгэхдээ БНБД 50-02-17г, Авто зогсоолын ажлын хийж гүйцэтгэхдээ БНБД 21-05-10г мөрдлөг болгон ажиллана. Ажил гүйцэтгэх хугацаанд Барилга хот байгуулалтын сайдын 2017.11.30-ны 195 дугаар "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам"-ын мөрдлөг

болгон ажиллана. Авто зогсоолд дүрэм журмын дагуу тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэнэ.

#### 4. 36-р байрны явган замын ажил

Явган хүний замын хашлага тавьж, хучилтыг өнгөт хавтангаар хийж гүйцэтгэнэ. Явган хүний замын ажлыг гүйцэтгэхдээ MNS 6808:2019 стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

#### Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.
7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
9. Ажил гүйцэтгэж дууссаны дараа шугамын трассын дагуу геодези хэмжилтийн байгууллагаар гүйцэтгэлийн зураг гаргуулж ГХБХБГ-ын кадастрын мэдээллийн санд бүртгүүлнэ.

#### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ

#### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

САЙНШАНД СУМЫН  
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

*Б.Энхманлай*

Б.ЭНХМАНЛАЙ